



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ-ээс

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг **зөвшилцөх**.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг дэмжив.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

Б.ГАНДИЙМАА

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ТЕХНОЛОГИ
ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ЯПОН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН
ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот


Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, С.Эрдэнэболд, Н.Батсүмбэрэл нар төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Монгол Улсад хэрэгжиж байгаа гэрээ, хэлэлцээрийн талаар мэдээлэл авах, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд энхийг дэмжих ажиллагаанд манай цэргийн албан хаагчид амжилттай оролцож байгаа талаар дурдаад, хэлэлцээрийн хүрээнд авах техник, тоног төхөөрөмж нь цаг үеийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцэх эсэх, энэ талаар тодорхой мэдээллийг Батлан хамгаалах яамнаас танилцуулж байх талаар тус тус үг хэлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН